



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 10 сарын 31 өдөр

Дугаар А/700

Ховд

Хөрөнгө гаргах тухай

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.1.1 дэх заалт, Аймгийн агаар, орчны бохирдлыг бууруулах дэд хөтөлбөрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Орон нутгийн "Агаарын бохирдлыг бууруулах, уур амьсгалын өөрчлөлтөнд зарцуулах зардал"-аас санхүүжүүлэх зорилгоор төсөл сонгон шалгаруулалт явуулсан дүн, байгуулсан гэрээ, санхүүжилтийн эрхийг үндэслэн хавсралтанд заасан аж ахуйн нэгжүүдэд холбогдох санхүүжилтийг олгосугай.

2. Шалгарсан аж ахуйн нэгжийг хавсралтаар баталсугай.

3. Дээрх арга хэмжээнд зарцуулах 450.000.000 төгрөг /дөрвөн зуун тавин сая/-ийг Орон нутгийн "Агаарын бохирдлыг бууруулах, уур амьсгалын өөрчлөлтөнд зарцуулах зардал"-аас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/, Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн даргыг түр орлон гүйцэтгэгч /Ц.Ганданповрон/ нарт зөвшөөрсүгэй.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч /Т.Жаргалсайхан/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ

№ 03436
Zax A/700 Ch

Аймгийн Засаг даргын 2019 оны
10 дугаар сарын 28-ны өдрийн
А/700 дугаар захирамжийн хавсралт.



АЙМГИЙН АГААР, ОРЧНЫ БОХИРДЛЫГ БУУРУУЛАХ ХӨТӨЛБӨРИЙН
ХҮРЭЭНД САНХҮҮЖИЛТ ОЛГОХ АЖ АХУЙН НЭГЖҮҮДИЙН ЖАГСААЛТ

Д/д	Аж ахуйн нэгжийн нэр	Төслийн нэр	Олгох санхүүжилт
1.	“Буянт үйлийн шим” хоршоо	Монгол гэрийн дулаалга	180,000,000
2.	“Зөөлөн тэмүүлэл констракшн” ХХК	Хогийн цэгийн хур хог цэвэрлэх	80,000,000
3.	“Тарвагатайн бэлчир” ХХК	Түлшний хэмнэлттэй зуух	70,000,000
4.	“Давшилт мөрөн” хоршоо	Хогийн цэгт гэрэлтүүлэг, камер суурьлуулах	19,928,800
5.	“Тэнгэрийн шагай” ХХК	Хогийн цэгт хашаа татах	80,000,000
	Нийт дүн		429,928,800

-oOo-

9+ 34